



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/24

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.3.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны шалны засварын ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Орхонтуул (Засаг даргын орлогч)

Гишүүд: Н.Нямхүү (Сургалтын менежер)

Д.Бадамбаяр (Биеийн тамирын багш)

Г.Бүд (Засаг даргын Тамгын газрын нярав)

М.Мандах (иргэний төлөөлөл)

2. Захиалагчийн техникийн тодорхойлолтод заасан шалгуурыг бүрэн хангасан тохиолдолд хүлээн авч, акт үйлдэн ажлын гүйцэтгэл, үр дүнг тайлагнахыг ажлын хэсэг (Н.Орхонтуул)-д даалгасугай.

3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ажлыг Ерөнхий боловсролын сургуулийн өмчийн бүртгэлд бүртгэж, ашиглалт хамгаалалтад байнгын хяналт тавьж ажиллахыг Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогч (Ц.Ариунсанаа), өмч хамгаалах зөвлөлд тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

